

Төв аймгийн Статистикийн хэлтэс

Н..... танаа



ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАР, 2008 ОНД

ЗУУНМОД

2009 он

ГАРЧИГ

I. МАЛЧДЫН ТОО, ТЭДНИЙ СОЁЛ, АХУЙН НӨХЦӨЛ

- I.1. Малчдын тоо, насны бүлэг
- I.2. Малчдын соёл, ахуйн нөхцөл

II. МАЛЫН ТОО, БҮТЭЦ

- II.1. Малын тооны өсөлт, бууралт
- II.2. Хувийн /амины/ малын тоо
- II.3. Хээлтэгч мал
- II.4. Төл бойжилт
- II.5. Том малын зүй бус хорогдол
- II.6. Малын хээл хаялт, сувайралт
- II.7. Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо
- II.8. Малын хэрэглээний зарлага
- II.9. Сүргийн бүтэц
- II.10. Цэвэр үүлрийн болон эрлийз, нутгийн шилдэг омгийн мал

III. МАЛЫН БЭЛЧЭЭР, ТЭЖЭЭЛИЙН ХҮРЭЛЦЭЭ, ХАНГАМЖ

- III.1. Бэлчээрийн хүрэлцээ

IV. ТЭЖЭЭВЭР АМЬТАД

V. СУДАЛГААНЫ ХЭСЭГ

VI. ДҮГНЭЛТ, САНАЛ

ӨМНӨХ ҮГ

Статистикийн тухай “ Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоолын дагуу Аймгийн Засаг Даргын дэргэдэх Статистикийн хэлтэс мал, тэжээвэр амьтад, тэжээлийн тооллогыг 2008 оны 12 сарын 7-ноос 17-ны өдрүүдэд зохион байгуулж, дүнг нэгтгэн гаргалаа.

Мал, тэжээвэр амьтад, тэжээлийн тооллогын 2005-2008 оны дүнд үндэслэсэн энэхүү танилцуулгад малчдын тоо, тэдний соёл, ахуйн нөхцөл, мал, тэжээвэр амьтад, тэжээлийн хүрэлцээ, хангамж зэрэг тооллогын үзүүлэлтүүдийг 4 жилийн гүйцэтгэлээр зэрэгцүүлэлт хийж харуулсан.

Монгол Улсын Газрын Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд малгүй болон мал цөөтэй иргэдийг малжуулах, мөн усны нөөцийн эх үүсвэрийг зохистой ашиглах замаар хөдөөгийн хүн ам, малын усны хангамжийг нэмэгдүүлэхэд анхаарч, худаг, уст цэгийг шинээр гаргах, сэргээн засварлахад зориулан, тодорхой хэмжээний хөрөнгө зарцуулдаг. Үүнтэй холбоотойгоор малжуулах болон усжуулах арга хэмжээний үр дүнг нэгтгэн дүгнэх зорилгоор 2008 оны мал тооллоготой хамруулан 3 дахь удаагаа зохион байгуулан явууллаа. Түүнчлэн “Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих “Үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд Дэлхийн банкны санхүүгийн дэмжлэгтэйгээр хэрэгжиж байгаа “Тогтвортой амьжиргаа” хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг бодитойгоор үнэлж, дүгнэх шаардлагыг харгалзан тус хөтөлбөрөөс малжуулалт, усжуулалтын талаархи мэдээллийг цуглуулан авч дүгнэлт хийх хүсэлт тавьсныг мөн мал тооллогын ажилтай хамтатган гүйцэтгэлээ. Энэ удаагийн судалгаанд мал аж ахуй, газар тариалан бүтээгдэхүүний гол нэр төрлийн үйлдвэрлэлийг биет хэмжээгээр оны болон зэрэгцүүлэх үнээр гаргаж судалгаанд шинээр нэмж оруулсан болно. Мөн малтай өрхөөс тусад нь малчин өрхийн хувийн малын бүлэглэлтийг нэмж тусгасан. Манай аймгийн мал аж ахуйн салбарын өнөөгийн байдалд дүгнэлт хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулах, төлөвлөхөд энэхүү танилцуулга судалгаа суурь материал болно гэдэгт итгэж байна.

ТОВЧ ТАЙЛБАР, ТОДОРХОЙЛОЛТ

Малтай өрх. Малчин өрхөөс гадна малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрхийг хэлнэ.

Малчин өрх. Жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болгож байгаа өрхийг хэлнэ.

Малчид. Жилийн 4 улирлын туршид мал аж ахуйг эрхэлж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болгож байгаа 16 ба түүнээс дээш насны хүмүүсийг хэлнэ.

Бодод шилжүүлэх коэффициент.

1 Адуу, үхэр- 1 бод,

1 тэмээ -1.5 бод,

6 хонь-1 бод

8 ямаа –1 бод

Бог малд буюу хонин толгойд шилжүүлэх коэффициент:

1 тэмээ-5 хонь

1 адуу- 7 хонь

1 үхэр- 6 хонь

1 хонь -1 хонь

1 ямаа- 0.9 хонь

Нас гүйцсэн мал. Малын төрөл бүр дээр сүүлчийн 2 насны малыг хэлнэ.

Тэмээ- 4 настай , 5 ба түүнээс дээш настай

Адуу- 3 настай, 4 ба түүнээс дээш настай

Үхэр- 2 настай, 3 ба түүнээс дээш настай

Бог мал – тухайн жилийн төл малаас бусад насны мал

Өсвөр насны мал .

Тэмээ-Өнгөрсөн жилийн төл, 2, 3 настай

Адуу- Өнгөрсөн жилийн төл, 2 настай

Үхэр- Өнгөрсөн жилийн төл

Төл мал. Тухайн жилийн төлийг хэлнэ.

Бэлэн хээлтэгч. Малын төрөл бүр дээр сүүлийн 2 насны эм малыг хэлнэ.

Малын тоо, толгойн өсөлт. Оны эцсийн малаас оны эхний малыг хасаж гаргана. Харьцангуй үзүүлэлтийг гаргахдаа оны эцсийн малын тоог эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

Малын өсөлтийн **орлого тал** нь төл бойжилт, **зарлага тал** нь хэрэглээний зарлага, том малын зүй бус хорогдол болно.

Төллөлтийн хувь. Төллөсөн хээлтэгчийн тоог оны эхний хээлтэгчийн тоонд харьцуулан, 100 –гаар үржүүлнэ.

Бойжилтийн хувь. Бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулан 100 –гаар үржүүлнэ.

100 эхээс бойжуулсан төл. Бойжуулсан төлийн тоог оны эхний хээлтэгч малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо. Хээлтэгч малын тоог хээлтүүлэгч малын тоонд харьцуулан гаргана. 1 хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тооны норм нь:

Буур - 20-25, Азарга - 12-15, Бух - 35-45, Хуц, ухна - 25-30

Малын зүй бус хорогдолд өвчний (халдвартай, халдваргүй) хорогдол, гэнэтийн аюулын (цас зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг) хорогдол, бусад шалтгааны (малын хариуллага, арчилгаа маллагаатай холбогдон гарсан) хорогдлыг оруулна.

Том малын зүй бус хорогдлын оны эхний малд эзлэх хувь. Зүй бусаар хорогдсон малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

Малын хэрэглээний зарлага.

1. Оны эхний малын тоон дээр бойжуулсан төлийг нэмж, том малын зүй бус хорогдол, оны эцсийн малын тоог хасч гаргана.
2. Хүнсний хэрэглээний малын тоо = Алдсан мал + Зах зээлд борлуулсан + Аж ахуйн дотоодод хэрэглэсэн + (Бусдад шилжүүлсэн - Худалдаж авсан, шилжиж ирсэн). Бусдад шилжүүлсэн > = Худалдаж авсан, шилжиж ирсэн

Учир нь худалдаж авсан эсвэл шилжиж ирсэн нэг хэсэг малаа идсэн байж болно. Идээгүй тохиолдолд дээрх 2 тэнцэж байх учиртай.

Малын хашааны хангамж. Хашааны хангамжийг гаргахдаа хашааны багтаамжийг малын тоонд харьцуулан гаргана. Бод малын хашааны хангамжийг гаргахдаа бодын хашааны багтаамжийг үхрийн тоонд, бог малынхыг гаргахдаа богийн хашааны багтаамжийг бог малын /хонь, ямааны/ тоонд харьцуулна.

Тэжээл хангамж. Тэжээлийн хангамжийг гаргахдаа тэжээлийн нэгжид шилжүүлсэн тэжээлийн хэмжээг хонин толгойд шилжүүлсэн малын тоонд харьцуулан гаргана. Малын тэжээлийн хангамж, бэлчээрийн даацыг гаргахдаа малыг хонин толгойд шилжүүлэн тооцно.

Тэжээлийн нэгжид шилжүүлэх коэффициент. Бэлтгэсэн тэжээл нь илчлэг, чанарын байдлаараа харилцан адилгүй байдаг учраас нэг тэжээлийн нэгжид шилжүүлэн тэжээлийн хангамжийг гаргадаг. Үүний тулд доорхи

Хадлан өвс -	0.45	Таримал тэжээл -	0.35
Даршны ургамал -	0.25	Гар тэжээл, хужир шүү -	1.0
Төмс ногооны хаягдал -	0.22	Үр тарианы хаягдал -	0.9

Лай - 0.4 Сүрэл - 0.25 гэсэн итгэлцүүрүүдийг ашиглан тэжээлийн нэгжид шилжүүлнэ.

Малын тэжээлийн ангилал. Малын тэжээлийг ургамлын гаралтай, амьтны гаралтай, эрдэс тэжээлийн гаралтай гэж ангилна.

- Ургамлын гаралтай тэжээлд өвс, сүрэл, үр тариа, буурцгийн төрлийн ургамал орох бөгөөд бүдүүн, хүчит, шүүст тэжээл гэж ангилна.
 1. Бүдүүн тэжээл - өвс, сүрэл, нэг наст ба олон наст өвс орно.
 2. Хүчит тэжээл - үр тариа, үр тарианы хаягдал, вандуй, буурцаг орно.
 3. Шүүст тэжээл - Бүх төрлийн дарш, төмс ногооны хаягдал орно.
- Амьтны гаралтай тэжээлд үйлдвэрийн мах, яс, цусны гурил зэрэг орно.
- Эрдэс тэжээлд давс, хужир шүү орно.

Эдийн засгийн бүсэд: **Баруун бүс** - Баянхангай, Бүрэн, Дэлгэрхаан, Заамар, Лүн, Өндөрширээт, Угтаал, Цээл, Эрдэнэсант

Хойт бүс - Аргалант, Батсүмбэр, Баянцогт, Баянчандмань, Борнуур, Жаргалант, Сүмбэр

Төвийн бүс - Алтанбулаг, Баян-Өнжүүл, Баянцагаан, Сэргэлэн, Зуунмод

Зүүн бүс - Архуст, Баян, Баяндэлгэр, Баянжаргалан, Мөнгөнморьт, Эрдэнэ

I. МАЛТАЙ ӨРХ, МАЛЧДЫН ТОО, ТЭДНИЙ СОЁЛ АХУЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

II.1. Малтай өрх, малчдын тоо. 2008 онд аминдаа малтай 13.6 мянган өрх, үүний дотор 9.1 мянган малчин өрх мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэв. Мөн мал аж ахуйн үйлдвэрлэлд 18.8 мянган малчид ажиллав. Малчдын 42.9 хувь нь буюу 8.1 мянга нь эмэгтэй малчид. Насны бүлгээр авч үзвэл 39.6 хувь нь 16-34 насны, 41.0 хувь нь 35-аас тэтгэвэрт гарах насны, 18.4 хувь нь тэтгэврийн насны хүмүүс байна. /Зураг 1/ Хүснэгт 1


Өрх, малчдын тоо, насны бүрэлдэхүүн

	2005	2006	2007	2008	<u>2008%</u> <u>2007</u>
Малтай өрх, (мян.)	12.9	13.3	13.4	13.6	101.5%
Малчин өрх, (мян.)	7.98	8.6	9.2	9.1	98.9%
Малчдын тоо (мян.)	17.5	16.9	18.9	18.8	99.5%
Үүнээс: 16-34 насны	8.13	7.32	7.98	7.46	93.5%
35-аас тэтгэвэрт гарах насны	6.35	6.7	7.81	7.93	101.5%
Тэтгэврийн	3.06	2.89	3.12	3.47	111.2%
Нийт малчдаас эмэгтэй	6.49	7.47	8.26	8.09	97.9%
Насны бүрэлдэхүүн %	100	100	100	100	
үүнээс: 16-34 насны	46.3	43.2	41.1	39.5	
35-аас тэтгэвэрт гарах насны	36.2	39.6	41.2	42.0	
Тэтгэврийн	17.4	17.1	16.5	18.4	
Нэг малчин өрхөд ногдох малын тоо	223	257	284	324	114.1%

2008 онд малчин өрхийн тоо 2008 онтой харьцуулахад 99-өөр, малчдын тоо 68-аар буурчээ. Бүрэн, Батсүмбэр, Аргалант, Эрдэнэ, Алтанбулаг, Сэргэлэн, Дэлгэрхаан, Баянжаргалан, Баянцагаан, Мөнгөнморьт, Баяндэлгэр зэрэг сумдад малчдын тоо буурч, бусад сумдуудад өслөө. Мөн малчин өрхийн тоо Борнуур, Цээл, Жаргалант, Заамар, Сэргэлэн, Мөнгөнморьт, Эрдэнэсант, Баянцогт, Баянжаргалан, Лүн, Өндөрширээт, Архуст өсч, бусад сумдуудад буурчээ. (Хавсралт 1). Бүсээр авч үзвэл нийт малчин өрхийн 39.4 хувь Баруун, 21.6 хувь нь Хойд, 19.9 хувь нь Төвийн, 18.9 хувь нь Зүүн бүсэд ногдлоо.

2008 онд 1 малчин өрхөд 328 толгой мал ногдож, 2007 оныхоос 44 толгойгоор нэмэгдлээ. Бүсээр авч үзвэл 1 малчин өрхөд ногдох малын тоо бүх бүсэд өслөө.

Зураг 1




I.2. Малчдын соёл, ахуйн үзүүлэлт. Нийт малчин өрхийн 70.7 хувь нь цахилгааны эх үүсгүүртэй, 61.8 хувь нь телевизортой, 28.4 хувь нь авто машинтай, 23.5 мотоцикльтай, 3.8 хувь нь трактортой бүртгэгдлээ.

Малчдын соёл ахуйн үзүүлэлтүүд

Хүснэгт 2

	Өрхийн тоо, тоогоор.				2008% 2007	Малчин өрхийн тоонд эзлэх хувь			
	2005	2006	2007	2008		2005	2006	2007	2008
Цахилгаантай	2791	3267	4479	6477	144.6	34.9	38.5	48.4	70.7
Телевизортой	2593	2884	4165	5654	135.8	32.4	34.0	45.0	61.8
Автомашинтай	1243	1491	2128	2491	117.1	15.5	17.9	23.5	28.4
Мотоцикльтай	1182	1411	1770	2148	121.4	14.9	16.6	19.1	23.5
Трактортой	255	295	267	351	131.5	3.1	3.4	2.8	3.8

Сумаар харуулсан дэлгэрэнгүй мэдээллийг /хавсралт 47/-д харуулав. Зураг 2



МАЛ АЖ АХУЙ

I. Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт

Мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2008 оны жинхэнэ гүйцэтгэлээр оны үнээр 96676.9 мянган төгрөг, 2005 оны зэрэгцүүлэх үнээр 66064.4 мянган төгрөгт хүрч, өмнөх оныхтой харьцуулахад оны үнээр **17.5** хувиар, зэрэгцүүлэх үнээр 2.99 хувиар өслөө (Хүснэгт 3).

МАЛ АЖ АХУЙН 2008 ОНЫ НИИТ БҮТЭЭГДЭХҮҮН- үнэ-мян төгрөг

	Бүгд						Хувийн аж ахуй			Компани, бусад		
	тонн		оны үнээр		зэрэгцүүлэх үнээр		Тонн	Оны үнээр	Зэрэгцүүлэх үнээр	Тонн	Оны үнээр	Зэрэгцүүлэх үнээр
	2007	2008	2007	2008	2007	2008	2008			2008		
МАХ-БҮГД	24,086.4	24,831.2	17,074.8	20,394.8	12,287.3	12,342.2	24,309.7	19,905.4	12,045.6	521.5	489.4	296.6
Тэмээ	93.9	5.9	65.8	5.5	39.8	2.5	0.6	0.6	0.3	5.3	4.9	2.3
Адуу	6,498.0	7,968.6	3,482.9	5,052.1	2,482.2	3,044.0	7,868.9	4,988.9	3,005.9	99.8	63.2	38.1
Үхэр	5,384.7	5,454.5	4,706.2	5,639.9	2,993.9	3,032.7	5,454.5	5,639.9	3,032.7	-	-	-
Хонь	8,096.0	6,396.4	6,242.0	5,865.5	4,630.9	3,658.7	6,115.0	5,607.4	3,497.8	281.4	258.0	161.0
Ямаа	3,916.8	4,935.4	2,310.9	3,558.4	1,966.2	2,477.6	4,821.5	3,476.3	2,420.4	113.9	82.1	57.2
Гахай	97.0	69.4	266.8	270.7	174.1	124.5	49.3	192.3	88.5	20.1	78.4	36.1
Шувуу	0.0	1.1	0.1	2.8	0.1	2.2	0.0	0.1	0.1	1.1	2.7	2.1
СҮҮ-БҮГД	35,630.4	35,033.0	19,008.0	23,006.6	19,166.6	18,885.2	34,137.0	22,415.9	18,399.6	896.0	590.7	485.6
Ингэний	28.4	33.9	18.6	22.6	12.3	14.6	33.5	22.3	14.5	0.4	0.3	0.2
Гүүний	4,822.0	4,214.0	2,102.4	2,600.0	1,851.7	1,618.2	4,125.5	2,545.4	1,584.2	88.5	54.6	34.0
Үнээний	23,732.2	23,054.5	13,313.7	14,547.4	13,764.7	13,371.6	22,461.7	14,173.3	13,027.8	592.8	374.1	343.8
Хонины	2,625.8	2,905.6	1,331.3	2,193.7	1,318.2	1,458.6	2,796.1	2,111.1	1,403.7	109.5	82.7	55.0
Ямааны	4,422.0	4,825.0	2,242.0	3,642.9	2,219.9	2,422.1	4,720.2	3,563.7	2,369.5	104.8	79.1	52.6
НООС-БҮГД	1,548.5	1,866.7	7,114.5	7,410.4	6,107.1	7,618.6	1,801.3	7,231.1	7,437.1	65.4	179.3	181.5
Тэмээний ноос	7.4	7.2	2.7	3.7	1.6	1.5	7.1	3.6	1.5	0.1	0.1	0.0
Хонины ноос	1,208.4	1,450.4	262.2	477.2	258.6	310.4	1,394.5	458.8	298.4	55.9	18.4	12.0
Ямааны ноолуур	220.4	275.8	6,736.1	6,873.4	5,742.7	7,188.3	269.4	6,713.8	7,021.4	6.4	159.6	166.9
Ямааны ноос	50.2	62.9	5.3	6.7	3.2	4.0	61.4	6.5	3.9	1.5	0.2	0.1
Бодын хөөвөр	22.2	25.2	8.1	14.5	3.0	3.3	24.6	14.2	3.3	0.6	0.3	0.1
Бодын хялгас	39.9	45.2	100.0	35.0	98.1	111.0	44.2	34.2	108.5	1.0	0.8	2.4
Өндөг (мян.ш)	6,387.0	147.7	894.2	34.1	517.3	12.0	60.8	14.0	4.9	86.9	20.1	7.0
Зөгийн бал (кг)	400.0	325.0	5.1	4.5	1.5	1.2	325.0	4.5	1.2	-	-	-
АРЬС-БҮГД	374.7	437.8	2,631.0	2,610.7	2,300.1	2,746.6	426.4	2,560.3	2,686.0	11.4	50.5	60.6
Тэмээ (мян.ш)	0.3	-	2.8	-	2.6	-	-	-	-	-	-	-
Адуу (мян.ш)	23.8	33.7	552.3	625.5	363.3	514.4	33.3	618.1	508.3	0.4	7.4	6.1
Үхэр (мян.ш)	20.1	24.5	441.4	467.8	335.3	408.8	24.4	465.8	407.1	0.1	1.9	1.7
Хонь (мян.ш)	206.4	186.7	799.0	571.9	917.4	829.9	179.3	549.2	797.0	7.4	22.7	32.9
Ямаа (мян.ш)	111.4	158.2	802.9	857.0	661.6	939.5	154.9	839.1	920.0	3.3	17.9	19.6
Хурга (мян.ш)	9.7	26.1	28.1	75.7	15.9	42.7	25.9	75.1	42.3	0.2	0.6	0.3
Ишиг (мян.ш)	3.0	8.6	4.5	12.9	3.9	11.3	8.6	12.9	11.3	-	-	-
МАЛЫН ӨСӨЛТ, ҮРЖИЛТ			31,353.6	35,889.8	24,985.8	23,520.6		34,373.2	22,540.9		1,516.6	979.8
АМЬТАДЫН ӨСӨЛТ, ҮРЖИЛТ			304.0	249.6	125.3	97.6		59.7	21.9		189.9	75.8
МАЛЫН ҮЛДЭЦ (мян.т)	103.4	125.0	1,034.0	3,000.0	361.9	437.5	120.3	2,886.0	420.9	4.8	114.0	16.6
ДҮН	79,728.6	96,676.9	66,064.4	68,102.9	66,064.4	68,102.9	93,526.5	65,999.4	65,999.4	3,150.4	2,103.5	2,103.5

Мал аж ахуйн салбарт 2008 онд нядалгааны жингээр 24831.2 тонн мах, 35033.0 тонн сүү, 1450.4 тонн хонины ноос, 257.8 тонн ноолуур, 7.2 тонн тэмээний ноос, 437.8 мянган ширхэг арьс шир үйлдвэрлэв.

II. Газар тариалангийн 2008 оны нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл

Газар тариалангийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2008 оны жинхэнэ гүйцэтгэлээр оны үнээр **42142.5** мянган төгрөг, **2005** оны зэрэгцүүлэх үнээр **20810.8** сая төгрөгт хүрч, өмнөх оныхтой харьцуулахад оны үнээр **45.46** хувиар, зэрэгцүүлэх үнээр **10.00** хувиар өслөө. /хүснэгт 4 /

ГАЗАР ТАРИАЛАНГИЙН 2008 ОНЫ НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН, үнэ-сая төгрөг- Төв															
	Бүгд														
	тонн			оны үнээр			зэрэгцүүлэх үнээр			Өрхийн аж ахуй			Компани, бусад		
	2008	2007	2006	2008	2007	2006	2008	2007	2006	тонн	оны үнээр	зэрэгцүүлэх үнээр	тонн	оны үнээр	зэрэгцүүлэх үнээр
ҮР ТАРИА-БҮГД	21,101.4	13,105.1	21,055.8	7,534.6	2,331.4	3,519.6	3,404.9	2,105.4	2,109.6	1,534.6	514.6	238.2	19,566.8	7,019.9	3,166.6
Буудай	20,438.2	12,436.0	20,750.3	7,411.2	2,244.4	3,486.1	3,311.0	2,026.8	2,089.6	1,274.0	462.0	207.6	19,164.2	6,949.2	3,123.3
Арвай	291.3	435.0	77.0	67.7	61.4	10.2	37.1	55.4	6.1	169.6	39.4	21.6	121.7	28.3	15.5
Овьёос	274.9	134.9	156.4	38.7	14.8	16.0	27.2	13.3	9.5	78.0	11.0	7.7	196.9	27.8	19.5
Бусад	97.0	99.2	72.1	17.0	10.9	7.4	9.6	9.9	4.4	13.0	2.3	1.3	84.0	14.7	8.4
													0.0	0.0	0.0
ТӨМС	27,439.1	27,387.1	25,668.3	21,766.7	13,636.4	11,910.1	12,347.6	12,324.2	8,316.5	20,452.3	16,224.2	9,203.5	6,986.8	5,542.5	3,144.1
ХҮНСНИЙ НОГОО	8,746.0	8,306.0	8,091.9	7,341.3	4,225.1	3,904.9	4,252.2	3,787.1	3,120.3	7,871.2	6,604.9	3,809.8	874.8	736.5	442.4
Байцаа	1,798.6	1,477.2	1,362.9	1,338.0	783.9	674.6	861.5	707.6	500.2	1,502.0	1,117.3	719.5	296.6	220.6	142.1
Маюкин	3,939.9	4,979.8	4,415.9	2,966.0	2,216.2	1,832.6	1,583.8	2,001.9	1,545.6	3,628.3	2,731.5	1,458.6	311.6	234.4	125.3
Лууван	2,372.9	1,477.7	1,930.1	1,930.2	757.2	907.1	1,079.7	672.3	760.5	2,180.9	1,775.1	992.3	192.0	155.1	87.3
Сонгино	149.4	117.5	67.2	216.8	134.4	69.7	150.0	118.0	47.0	125.3	182.5	125.8	24.1	34.3	24.1
Сармис	0.0	0.8	2.1	0.0	1.3	3.2	0.0	1.2	1.8	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Өргөст хэмх	68.2	35.4	89.4	131.8	59.8	136.9	101.1	52.4	93.7	47.8	92.9	70.9	20.4	38.9	30.2
Улаан лооль	40.6	7.4	37.2	117.7	22.2	80.8	85.3	15.6	52.0	39.0	113.4	82.1	1.6	4.3	3.3
Тарваас, гуа	3.9	1.0	0.9	8.8	1.9	1.2	5.0	1.3	0.7	1.8	4.3	2.3	2.1	4.5	2.7
Бусад	372.6	209.2	186.2	632.2	248.2	198.9	385.8	216.9	118.8	346.0	587.8	358.4	26.5	44.4	27.4
МАЛЫН ТЭЖЭЭЛ	109,556.2	82,028.2	99,374.9	4,187.7	2,219.0	2,552.9	0.0	0.0	0.0	99,374.9	2,552.9	0.0	116,603.1	4,411.5	0.0
Наг наст	1,798.0	652.4	897.0	54.0	18.8	24.1	0.0	0.0	0.0	897.0	24.1	0.0	0.0	0.0	0.0
Олон наст	163.0	154.4	25.5	4.9	4.5	0.7	0.0	0.0	0.0	25.5	0.7	0.0	59,761.3	2,248.8	0.0
Даршны ургамал	2,305.0	86.0	25.0	117.4	3.5	0.9	0.0	0.0	0.0	25.0	0.9	0.0	10.0	0.3	0.0
Хадлан	92,470.1	70,587.7	85,838.1	3,663.3	1,946.3	2,207.8	0.0	0.0	0.0	85,838.1	2,207.8	0.0	750.0	22.5	0.0
Сүрэл	3,208.8	701.0	594.4	59.4	8.6	6.8	0.0	0.0	0.0	594.4	6.8	0.0	0.0	0.0	0.0
Гар тэжээл	1,072.3	1,572.2	2,026.1	31.6	39.4	47.4	0.0	0.0	0.0	2,026.1	47.4	0.0	50,171.0	1,987.6	0.0
Хужир, шүү	7,599.0	6,363.4	5,772.7	197.3	119.6	101.2	0.0	0.0	0.0	5,772.7	101.2	0.0	150.0	2.8	0.0
	0.0	159.2	110.0	0.0	4.3	2.8	0.0	0.0	0.0	110.0	2.8	0.0			
Техникийн ургамал	940.0	1,751.9	4,086.1	59.9	74.1	161.2	0.0	0.0	0.0	4,086.1	161.2	0.0	5,760.8	149.5	0.0
ЖИМС, ЖИМСГЭНЭ	73.4	6.6	0.9	124.5	7.3	0.9	75.4	6.6	0.6	0.9	0.9	0.6			
Дуусаагүй үйлдвэрлэл				1,190.4	562.5	-635.4	730.7	505.5	-109.7				1,190.4		
ДҮН	42,145.2	22,981.8	21,253.0	20,810.8	18,728.7	13,437.3	25,897.6	13,252.2	18,900.8	7,483.8					

II. МАЛ, ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТОО, БҮТЭЦ

II.1. Малын тоо. Манай аймгийн малын тоо 2008 оны эцэст 3002.9 мянгад хүрч, 2007 оныхоос 376.4 мянгаар буюу 14.3 хувиар өслөө. 2007 оныхоос тэмээ 0.2 мянга, үхэр 14.3 мянга, хонь 200.5 мянга, ямаа 163.4 мянган толгойгоор тус тус өсч, харин адуу 2.26 мянган толгойгоор буурлаа. 2008 онд малын тооны өсөлт үндсэндээ хонь, ямааны тоо толгойн өсөлтөөр хангагдав (Хавсралт 7, 8). Малын тоо толгой өсөхөд 2007 оныхоос 67.1 мянган төл илүү бойжуулж, хээлтэгч малын тоо 190 мянгаар өссөн нь нөлөөллөө.


Малын тоо, төрлөөр. мян.тол. Хүснэгт 5

	2005	2006	2007	2008	2008%	2008%	2008/2007	
					2005	2006	%	Зөрүү
Бүгд	1780.3	2173.2	2626.5	3002.9	168.7	138.2	114.3	376.4
Тэмээ	2.2	2.1	2.0	2.3	104.5	109.5	115.0	0.3
Адуу	179.4	197.8	214.9	212.7	118.6	107.5	99.0	-2.2
Үхэр	108.1	131.1	157.1	171.5	158.6	130.8	109.2	14.4
Хонь	855.7	1040.8	1249.2	1449.7	169.4	139.3	116.1	200.5
Ямаа	634.9	801.2	1003.0	1166.4	183.7	145.6	116.3	163.4

Малын тоо, бүс нутгаар. мян.тол. Хүснэгт 6


Бүс	2005	2006	2007	2008	2008/2007	
					%	Зөрүү
Баруун	664.4	820.51	1064.67	1201.77	112.9	137.1
Хойт	292.06	367.15	468.31	625.30	133.5	156.99
Төв	450.21	535.16	586.73	604.86	103.1	18.13
Зүүн	373.55	450.4	506.82	571.01	112.7	64.19

Зураг 3



Мал тооллогын дүнгээр Баянжаргалан, Баянцагаан, Бүрэн, Дэлгэрхаан, Угтаал сумаас бусад бүх сум өсгөсөн. Батсүмбэр, Баяндэлгэр, Баянхангай, Баянцогт, Заамар, Лүн, Цээл, Эрдэнэсант сумд малаа таван төрөл дээр нь өсгөсөн. (Хавсралт 5).

Бүс нутгаар авч үзвэл Баруун бүсийн мал 2007 оныхоос 148.0 мянгаар буюу 19.3 хувиар, Хойт бүсийн мал 141.07 мянгаар буюу 30.1 хувиар, Зүүн бүсийн мал 70.0 мянгаар буюу 13.8 хувиар, Төвийн бүсийн малын 17.2 мянгаар буюу 2.9 хувиар тус тус өслөө. Зураг 4



Малын тооны өсөлт, бууралтад нөлөөлсөн үзүүлэлтүүд. мян.тол Хүснэгт 7


	2005	2006	2007	2008	2008/2007	
					%	Зөрүү
Бойжуулсан төл	580.8	700.1	825.5	892.6	108.1	67.1
100 эхээс бойжуулсан төл	84.0	89.0	86.0	78.0	90.7	-8.0
Том малын зүй бус хорогдол	16.1	14.8	13.1	93.4	713.0	80.3
Хээлтэгч малын тоо	782.9	963.1	1150.5	1340.5	116.5	190.0
Хээл хаясан хээлтэгч	15.6	14.3	16.7	34.1	204.2	17.4
Сувайрсан хээлтэгч	39.9	33.7	48.5	68.1	140.4	19.6

Малын тооны өсөлтөнд бойжсон төл, хээлтэгч малын тоо нэмэгдсэн нь нөлөөллөө.

Нийт сүрэгт таван төрлийн малын эзлэх хувь Хүснэгт 8


	2005	2006	2007	2008
Бүгд	100	100	100	100
Тэмээ	0.12	0.09	0.07	0.08
Адуу	10.07	9.1	8.18	7.08
Үхэр	6.07	6.03	5.98	5.71
Хонь	48.06	47.89	47.56	48.28
Ямаа	35.66	36.87	38.18	38.84

Зураг 5



2008 онд аймагт нийт мал болон адуу, хонь, ямааны тоогоор Эрдэнэсант, тэмээгээр Баянжаргалан, үхрээр Батсүмбэр сум тэргүүллээ. (Хавсралт 5. 2)

2007 оны малын тоо, сумаар. Зураг 6



II.2. Хувийн малын тоо. 2008 онд хувийн малын тоо 2907.5 мянгад хүрч, нийт малын 96.8 хувийг эзлэв. Тэмээний 99.2 хувь, адууны 97.8, үхрийн 96.8, хонины 95.9, ямааны 97.6 хувь нь хувийн аж ахуйд ногдлоо. (Хавсралт 5). Хувийн малын тоо 2007 оныхоос 360.6 мянгаар буюу 14.1 хувиар өслөө.

Хувийн малтай өрх, тэдгээрийн малын тоо. мян.тол. Хүснэгт 9

	Малтай өрхийн тоо, мян.өрх	Бүгд	үүнээс				
			Тэмээ	адуу	үхэр	хонь	ямаа
2005	12.9	1711.10	2.09	173.10	105.09	813.98	616.84
2006	13.3	2094.40	2.10	191.56	126.75	995.26	778.73
2007	13.4	2546.87	2.06	210.85	153.10	1201.14	979.72
2008	13.6	2907.48	2.35	208.20	166.15	1391.65	1139.13

Хувийн аж ахуйд байгаа малын 39.1 хувийг ямаа, 47,8 хувийг хонь, 7.1 хувийг адуу, 5.7 хувийг үхэр, 0,08 хувийг тэмээ эзлэв. (Хавсралт 5).

Малтай өрхийн малын бүлэглэлт.

1000 дээш малтай 422 өрх тоологдсон бөгөөд 2007 оныхоос 85 өрхөөр нэмэгдлээ. 1000-аас дээш малтай өрхийн тоогоор Эрдэнэсант сум тэргүүлж, удаахь байранд Лүн сум орлоо. (Хавсралт 36). Хүснэгт 10

	Малтай өрхийн тоо				Дүнд эзлэх хувь				Малын тоо, мян.тол			
	2005	2006	2007	2008	2005	2006	2007	2008	2005	2006	2007	2008
Дүн	12920	13346	13475	13683	100.0%	100.0%	100.0%	100.0%	1711.12	2094.40	2546.86	2907.48
100 хүртэл малтай	7892	7464	6596	6383	61.08%	55.93%	48.95%	46.65%	283.02	265.34	246.86	241.61
101-200 малтай	2376	2515	2763	2698	18.39%	18.84%	20.50%	19.72%	345.98	361.76	395.33	398.31
201-500 малтай	2071	2482	2865	3053	16.03%	18.60%	21.26%	22.31%	628.99	759.48	886.39	974.06
501-999 малтай	453	684	914	1127	3.51%	5.13%	6.78%	8.24%	300.16	457.04	594.03	758.35
1000-1499 малтай	110	177	292	366	0.851%	1.326%	2.167%	2.675%	120.88	203.98	336.93	425.47
1500-2000 малтай	15	15	30	34	0.116%	0.112%	0.223%	0.248%	24.67	24.63	51.00	56.56
2001-ээс дээш малтай	3	9	15	22	0.023%	0.067%	0.111%	0.161%	7.42	22.17	36.32	53.12

I.3 Хээлтэгч мал. 2008 оны эцэст 1340.5 мянган толгой хээлтэгч мал тоологдсон нь өнгөрсөн 2007 оныхоос 190.0 мянган толгойгоор нэмэгдсэний дотор тэмээ 0.16, адуу 1.39, үнээ 7.02 мянгаар, эм хонь 99.36 мянгаар, эм ямаа 82.07 мянгаар тус тус нэмэгдлээ. (Хавсралт 11).

Хээлтэгч малын тоо. мян.тол. Хүснэгт 11

	2005	2006	2007	2008	2008/2007	
					%	Зөрүү
Бүгд	782.9	963.1	1150.5	1340.5	116.5	190.00
Тэмээ	0.6	0.6	0.6	0.8	125.4	0.16
Адуу	53.3	57.8	63.1	64.5	102.2	1.39
Үхэр	44.3	52.4	61.9	68.9	111.4	7.02
Хонь	400.0	488.0	577.7	677.1	117.2	99.36
Ямаа	284.7	364.4	447.2	529.3	118.4	82.07

Хээлтэгч мал нийт малын 44.6 хувийг эзэлж байгаа бөгөөд тэмээн сүргийн 33.3 хувь, адуун сүргийн 30.30 хувь, үхэр сүргийн 40.14 хувь, хонин сүргийн 46.7 хувь, ямаан сүргийн 45.3 хувийг тус тус эзлэв. Сумаар авч үзвэл малын тоо нь буурсан Алтанбулаг, Баянцагаан, Дэлгэрхаан, Угтаал сумын хээлтэгч малын тоо буурч, бусад сумдуудад хээлтэгч малын тоо нэмэгджээ (Хавсралт 9.10.11). Бүсээр авч үзвэл бүх бүсэд хээлтэгч малын тоо өслөө.


II.4 Төл бойжилт. 2008 онд гарсан төлийн 93.9 хувийг буюу 892.6 мянган төл бойжуулав. Бойжсон төлийн тоо 2007 оныхоос 67.1 мянган толгойгоор, бойжилтын хувь 8.1-ээр өслөө. Гарсан ботгоны 85.0 хувь, унаганы 90.1 хувь, тугалны 94.9 хувь, хурганы 94.7 хувь, ишигний 93.3 хувийг бойжууллаа.

Төл бойжилт. мян.тол Хүснэгт 12

	Бүгд				үүнээс				
	2005	2006	2007	2008	ботго	унага	тугал	хурга	Ишиг
Гарсан төл	598.8	714.3	846.9	949.8	0.4	40.3	48.4	492.5	368.2
Бойжсон төл	580.8	700.1	825.5	892.6	0.3	36.3	45.9	466.4	343.6
Бойжилтийн хувь	96.9	98.0	97.5	94.0	85.0	90.1	94.9	94.7	93.3

Баян, Баянжаргалан, Баян-Өнжүүл, Баянцагаан, Бүрэн, Дэлгэрхаан, Зуунмод сумдаас бусад бүх сумдад бойжуулсан төлийн тоо 2007 оныхоос өслөө.

(Хавсралт 15). Зураг 7



Бүсээр авч үзвэл төвийн бүсээс бусад бүх бүсэд бойжуулсан төлийн тоо нэмэгджээ. Нийт бойжуулсан төлийн 41.4 хувь нь Баруун бүсэд, 19.3 хувь нь Хойт бүсэд, 19.6 хувь нь Төвийн бүсэд, 19.5 хувь нь Зүүн бүсэд ногдлоо.


Бойжуулсан төл- мян.тол Хүснэгт 13

	2005	2006	2007	2008
Бүгд	580.76	700.09	825.53	892.6
Тэмээ	0.3	0.28	0.28	0.34
Адуу	38.65	40.51	41.57	36.32
Үхэр	33.14	39.13	47.27	45.92
Хонь	289.84	362.74	421.48	466.39
Ямаа	208.82	257.43	314.93	343.63

Аймгийн дунджаар 100 эхээс 78 төл бойжууллаа. 100 эхээс бойжуулсан төлийн тоо 2007 оныхоос 8.0-аар буурч, тэмээнээс бусад бүх төрөл дээрээ буурлаа.

(Хавсралт 17).

100 Эхээс бойжуулсан төл. Зураг 8



100 эхээс бойжуулсан төл. Хүснэгт 14

	2005	2006	2007	2008
Бүгд	84	89	86	78
Тэмээ	43	45	47	55
Адуу	73	76	72	58
Үхэр	83	88	90	74
Хонь	85	91	86	81
Ямаа	86	90	86	77


II.5 Том малын зүй бус хорогдол. 2008 онд оны эхэнд байсан нийт мал сүргийн 3.56 хувь нь буюу 93.4 мянган толгой том мал хорогдсон нь 2007 оныхоос 80.0 мянга буюу 13.3 дахин өслөө. 2007 онтой харьцуулахад таван төрлийн том малын бүх төрөл дээр өсчээ. Нийт хорогдлын 44.02 хувийг хонь, 37.7 хувийг ямаа, 8.0 хувийг үхэр, 10.20 хувийг адуу, 0.05 хувийг тэмээ эзлэв.

Том малын зүй бус хорогдол- мян.тол Хүснэгт 15

	2005	2006	2007	2008
Бүгд	16.50	14.82	13.41	93.48
Тэмээ	0.01	0.01	0.02	0.05
Адуу	2.24	1.99	1.64	9.53
Үхэр	1.42	1.26	1.25	7.49
Хонь	6.98	6.42	6.10	41.16
Ямаа	5.83	5.14	4.40	35.25

Эрдэнэ, Баянчандмань, Батсүмбэр, эдгээр 3 сумаас бусад бүх сумдад хорогдол өслөө. (Хавсралт 18).

Зураг 9



Нийт хорогдлын 56.1 хувийг Баруун бүс, 4.9 хувийг Хойт бүс, 13.50 хувийг Зүүн бүс, 25.40 хувийг Төвийн бүс эзэлжээ.

Оны эхний малд зүй бүс хорогдлын эзлэх хувь. Хүснэгт 16

	2005	2006	2007	2008
Бүгд	1.06	0.68	0.51	3.56
Тэмээ	0.66	0.65	1.38	2.24
Адуу	1.32	1.01	0.76	4.44
Үхэр	1.52	0.96	0.79	4.76
Хонь	0.93	0.61	0.48	3.29
Ямаа	1.07	0.64	0.43	3.51

Гэнэтийн аюулаар хорогдсон малын тоо 2007 оныхоос 33.5 мянган толгойгоор буюу 2.6 дахин буурлаа. Гэнэтийн аюулаар хорогдсон малын 29.70 хувийг бог мал, 70.29 хувийг бод мал эзэлжээ. Нийт хорогдлын 37.2 хувь нь гэнэтийн аюулаар, 24.1 хувь нь өвчнөөр болон бусад шалтгаанаар хорогджээ.

Гэнэтийн аюулаар хорогдсон малын тоо-мян.тол. Хүснэгт 17

	2005	2006	2007	2008
Бүгд	2673	4641	1286	34789
Тэмээ	0	0	0	10
Адуу	649	904	187	3604
Үхэр	275	350	195	2637
Хонь	975	1774	456	14182
Ямаа	774	1613	448	14356

II.6. Малын хээл хаялт, сувайралт. 2008 онд оны эхний хээлтэгч малын 8.89 хувь нь буюу 102.31 мянган мал хээл хаяж, сувайрсны улмаас төл өгөөгүй байна. Хээлтэгч малын тоо 2007 оныхоос 14.17 хувиар буюу 189.99 мянгаар өсчээ. Төл өгөөгүй хээлтэгч малын 66.65 хувь буюу 68.19 мянгыг сувайрсан хээлтэгч, 33.35 хувь буюу 34.12 мянга нь хээл хаясан хээлтэгч юм.

Хээл хаяж, сувайрсан эх малын тоо. мян.тол. Хүснэгт 18

	Төл өгөөгүй хээлтэгч		2008 2007	Сувайрсан		2008 2007	Хээл хаясан		2008 2007
	2007	2008		2007	2008		2007	2008	
Бүгд	65253	102314	156.80	48522	68194	140.54	16731	34120	203.93
Ингэ	23	58	252.17	20	53	265.00	3	5	166.67
Гүү	7901	12095	153.08	6243	8375	134.15	1658	3720	224.37
Үнээ	4100	7742	188.83	3441	6156	178.90	659	1586	240.67
Эм хонь	28773	42175	146.58	21460	28234	131.57	7313	13941	190.63
Эм ямаа	24456	40244	164.56	17358	25376	146.19	7098	14868	209.47

Сумаар авч үзвэл Баянхангай, Угтаал, Баянчандмань, Баянцагаан, Мөнгөнморьт, Алтанбулаг, Баянцогт суманд төл өгөөгүй хээлтэгч малын тоо 2007 оныхоос бусад бүх суманд өслөө. (Хавсралт 22.23).

Оны эхний хээлтэгчид хээл хаялт, сувайралтын эзлэх хувь - Хүснэгт 19

	Төл өгөөгүй хээлтэгч			Сувайрсан			Хээл хаясан		
	2006	2007	2008	2006	2007	2008	2006	2007	2008
Бүгд	6.1	6.8	8.9	4.3	5.0	5.9	1.8	1.7	3.0
Ингэ	4.0	3.7	9.2	3.7	3.2	8.4	0.3	0.5	0.8
Гүү	12.8	13.7	19.2	9.9	10.8	13.3	2.9	2.9	5.9
Үнээ	9.7	7.8	12.6	8.3	6.6	10.0	1.4	1.3	2.6
Эм хонь	5.0	5.9	7.3	3.5	4.4	4.9	1.5	1.5	2.4
Эм ямаа	5.9	6.7	9.0	3.8	4.8	5.7	2.1	1.9	3.3

Хээл хаяж, сувайралсан эх малын 40.78 хувь нь Баруун, 15.51 хувь нь Хойт, 16.08 хувь нь Зүүн, 27.6 хувь нь Төвийн бүсэд ногдлоо.

Зураг 10



II.7. Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо. Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо нь бод малын хувьд нормоор, харин бог малын хувьд алдагдсан хэвээр байна. 2008 онд 26.02 мянган хээлтүүлэгч мал тоологдож, 2007 оныхоос 4.06 мянган толгойгоор буюу 14 хувиар өслөө. 2007 оныхоос азарга 0.1 мянгаар буурч, харин буур, бух, хуц, ухны тоо 0.46-0.01 мянгаар нэмэгджээ.

Хээлтүүлэгч малын тоо-толгой. Хүснэгт 20

	Бүгд				Үүнээс шинээр тавьсан			
	2005	2006	2007	2008	2005	2006	2007	2008
Бүгд	19.50	20.81	24.87	26.01	0.020	0.090	0.022	0.041
Буур	0.04	0.04	0.03	0.04	0.000	0.000	0.000	0.000
Азарга	7.65	8.00	8.38	8.37	0.010	0.032	0.009	0.024
Бух	1.26	1.51	1.72	1.92	0.004	0.010	0.006	0.017
Хуц	6.16	6.24	8.24	8.72	0.008	0.034	0.005	0.000
Ухна	4.37	5.02	6.50	6.96	0.006	0.023	0.002	0.000

Үржлийн нормоор бог малын нэг хээлтүүлэгчид 25-30 хээлтэгч ногдох ёстой байхад 2008 онд аймгийн дунджаар 78 эм хонь, 76 эм ямаа ногдож, 2 дахин гаруй өндөр үзүүлэлт гарлаа (Хавсралт 12).

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо. Хүснэгт 21

	Үржлийн норм	2005	2006	2007	2008
Ингэ	20-25	14	14	18	18
Гүү	12-15	7	7	8	8
Үнээ	35-45	35	35	36	36
Эм хонь	25-30	65	38	70	78
Эм ямаа	25-30	65	73	69	76

II.8. Малын хэрэглээний зарлага. 2008 онд оны эхний нийт малын 14.07 хувь буюу 422.8 мянган малыг хэрэглээнд зарцуулсан.

Малын хэрэглээний зарлага- мян.тол. Хүснэгт 22

	2005	2006	2007	2008
Бүгд	272.99	261.95	323.1	422.8
Тэмээ	0.21	0.2	0.18	0
Адуу	19.19	17.84	19.86	29.1
Үхэр	16.52	15.54	19.9	24.1
Хонь	139.38	136.41	165.84	224.7
Ямаа	97.67	91.96	117.32	144.9


Хэрэглээнд зарцуулсан малын 87.41 хувийг бог мал, 12.58 хувийг бод мал эзлэв.

Зах зээлд худалдан борлуулсан болон аж ахуйн дотоодод хэрэглэсэн

малын тоо-мян.тол. Хүснэгт 23


	Зах зээлд худалдан борлуулсан				Аж ахуйн дотоодод хэрэглэсэн			
	2005	2006	2007	2008	2005	2006	2007	2008
Бүгд	130.27	128.8	162.35	207.08	142.69	133.15	160.73	175.33
Тэмээ	0.15	0.13	0.12	0.18	0.05	0.07	0.05	0.05
Адуу	10.16	9.78	11.18	13.8	9.03	8.06	8.68	9.4
Үхэр	7.34	6.46	9.21	11.86	9.49	9.08	10.69	12.57
Хонь	67.84	69.51	86.7	107.1	71.53	66.9	79.14	86.32
Ямаа	45.08	42.92	55.14	74.14	52.59	49.04	62.17	66.99

Хэрэглээнд зарцуулсан малын 49.05 хувийг зах зээлд худалдан борлуулж, 41.4 хувийг аж ахуйн дотоод хэрэгцээнд зарцуулжээ. Зураг 11



II.9. Сүргийн бүтэц. 2008 оны байдлаар нийт сүргийн 33.18 буюу 996.34 мянган толгой нь төл, өсвөр насны мал, 21.31 хувь буюу 640.06 мянган толгой нь нас гүйцсэн мал, 44.64 хувь буюу 1340.51 мянган толгой нь хээлтэгч мал, 0.87 хувь буюу 26.02 мянган толгой нь хээлтүүлэгч мал эзлэв. (Хавсралт 25.26).

Сүргийн бүтэц. Зураг 12



Өнгөрсөн оныхоос төл өсвөр насны 80.35 мянгаар, нас гүйцсэн мал 104.9, хээлтэгч 189.9, хээлтүүлэгч 1.12 мянгаар өслөө.

Сүргийн бүтэц, хувиар. Хүснэгт 24

	Төл, өсвөр насны				Нас гүйцсэн эр			
	2005	2006	2007	2008	2005	2006	2007	2008
Бүгд	35.55	35.26	34.87	33.18	19.38	19.46	20.37	21.31
Тэмээ	31.1	30.93	33.01	37.23	38.2	38.04	35.2	27.51
Адуу	40.36	41.89	41.47	39.29	25.68	24.86	25.28	26.46
Үхэр	48.87	49.15	49.29	47.41	8.95	9.71	10.25	11.32
Хонь	34.67	34.57	34.17	33.13	17.86	17.94	18.91	19.57
Ямаа	33.11	32.25	32.07	30.03	21.37	21.64	22.69	24

үргэлжлэл

	Хээлтэгч				Хээлтүүлэгч			
	2005	2006	2007	2008	2005	2006	2007	2008
Бүгд	43.98	44.31	43.80	44.64	1.10	0.95	0.94	0.87
Тэмээ	28.62	29.01	30.06	33.36	2.06	2.01	1.71	1.89
Адуу	29.69	29.18	29.34	26.46	4.27	4.04	3.90	3.94
Үхэр	41.01	39.96	39.35	40.15	1.17	1.15	1.09	1.12
Хонь	46.75	46.88	46.24	46.70	0.72	0.59	0.66	0.60
Ямаа	44.84	45.47	44.58	45.37	0.69	0.62	0.64	0.60

II.10 Цэвэр үүлдэр болон эрлийз, нутгийн шилдэг омгийн мал. 2008 оны эцэст цэвэр үүлдрийн 4.86 мянган мал, эрлийз 70.87 мянга, нутгийн шилмэл омгийн 10.74 мянган мал тоологдов.

Цэвэр болон эрлийз нутгийн шилдэг омгийн малын тоо-мян.тол.Хүснэгт 25

	2005	2006	2007	2008	2008/2007	
					%	зөрүү
Цэвэр үүлдрийн мал	4.10	14.00	6.32	4.86	76.90	-1.46
Үхэр	3.60	5.01	3.63	3.08	84.85	-0.55
Хонь	0.50	8.78	1.44	0.87	60.42	-0.57
Ямаа	0.00	0.20	1.25	0.90	72.00	-0.35
Эрлийз мал	12.80	29.88	27.56	70.87	257.15	43.31
Үхэр	12.80	21.18	19.27	20.48	106.27	1.21
Хонь	0.00	4.74	6.58	47.61	723.56	41.03
Ямаа	0.00	3.96	1.71	2.78	162.69	1.07
Нутгийн шилдэг омгийн мал	6.80	20.89	11.59	10.74	92.67	-0.85
Үхэр	0.00					0.00
Хонь	24.32	1.05	4.56	7.23	158.55	2.67
Ямаа	23.40	19.65	6.99	3.49	49.93	-3.50
Тэмээ	0.00					0.00
Адуу	0.96	0.19	0.03	0.03	96.67	0.00
Сайжруулсан нутгийн	-	-	53.42	69.14	-	-
Тэмээ	-	-			-	-
Адуу	-	-	1.66	1.86	-	-
Үхэр	-	-			-	-
Хонь	-	-	34.96	15.97	-	-
Ямаа	-	-	16.80	51.31	-	-

2008 оны мал тооллогоор манай аймагт өсгөн үржүүлж байгаа цэвэр, эрлийз үүлдрийн болон шилдэг омгийн малын талаар ХХААЯ-наас шинэчлэн баталж ирүүлсэн жагсаалтыг үндэслэн үүлдрийн болон шилдэг омгийн мал, түүгээр сайжруулсан нутгийн үүлдрийн малын ангилалд зохих ёсоор өөрчлөлт оруулсан. Үүний дагуу дээрхи 4 ангилалаар үр дүнг гарган авлаа.


Энэхүү ангилалын дагуу дүнг нэгтгэн гаргахад цэвэр үүлдрийн мал нийт малын 0,16 хувийг, эрлийз үүлдрийн мал 2.36 хувийг, нутгийн шилдэг омгийн мал 2.30 хувийг эзлэв. (Хавсралт 28)

III.2. Малын тэжээлийн үйлдвэрлэлт, хангамж. 2008 онд бэлтгэсэн тэжээлийг нэр төрлөөр авч үзвэл байгалын хадлан 21882.5 ногоон тэжээл 1202.6, сүрэл 2507.8 тэжээл үйлдвэрлэлт 11182.1 тонноор өсч, бэлтгэсэн дарш 26.8 тонн, гар тэжээл 499.7 тонноор буурлаа

Бэлтгэсэн тэжээл, нэр төрлөөр. (тонноор)Хүснэгт 26

	2005	2006	2007	2008	<u>2008</u> <u>2007</u>
Байгалийн хадлан	60233.60	85838.10	70587.66	92470.10	131.00
Сүрэл	504.00	594.40	701.00	3208.80	457.75
Ногоон тэжээл	1200.00	947.50	595.40	1798.00	301.98
Гар тэжээл	2966.90	2026.12	1572.15	1072.39	68.21
Бэлтгэсэн дарш	67.70	450.00	92.00	65.20	70.87
Тэжээл үйлдвэрлэлт	35626.70	47072.80	40497.50	51679.60	127.61

Зураг 13



ТЭЖЭЭВЭР АМЬТАД

2007 оныхоос 292 гахай, зөгий бүл 112, буга 15, илжиг 1-ээр урьд оноос буурлаа. Шувуу урьд оноос 35.3 мянгаар өслөө.

Тэжээвэр амьтад, тэдгээрийг өсгөн үржүүлдэг өрхийн тоо.Хүснэгт 27

	2005	2006	2007	2008	<u>2008</u> <u>2007</u>
Гахай (мян.тол)	2496	2965	3754	3462	92.22
Шувуу (мян.тол)	1902	20993	52020	87325	167.87
Буга-тэжээвэр	34	33	39	24	61.54
Илжиг	3	3	4	3	75.00
Зөгий (бүл)	102	23	177	65	36.72
Туулай	127	49	66	144	218.18
Гахайтай өрхийн тоо (мян.)	322	201	191	277	145.03
Шувуутай өрхийн тоо(мян.)	160	187	132	89	67.42

Гахайтай өрхийн тоо өмнөх оны мөн үеэс 86 өсч , шувуутай өрхийн тоо 43-аар буурлаа (Хавсралт 42.2)

Монгол улсын Засгийн газрын Ядуурлыг бууруулах зорилгоор үндэсний хөтөлбөр хүрээнд малгүй айлыг малжуулах арга хэмжээг авч, нилээдгүй хөрөнгө мөнгийг зарцуулжээ. Малжуулах арга хэмжээ нь орон нутаг, гадаад улс орон, олон улсын байгууллага, төрийн бус байгууллага зэрэг олон улсын санхүүжилтаар хийгдлээ. 2008 оны байдлаар 369 өрх хамрагдсан бөгөөд өмнөх оноос 35.71 %-иар буурчээ. (Хавсралт 47). Хүснэгт 28

2008 ОНД МАЛЖУУЛАЛТЫН ТАЛААР АВСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН

Сумын нэр	Нийт зарцуулсан хөрөнгийн хэмжээ бүгд (мян,төг)	Үүнээс			Малжуулалтаар авсан малын тоо (6+7)	Малжуулалтанд хамрагдсан			
		Гадаад орон, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөр (мян,төг)	Орон нутгийн хөрөнгөөр (мян,төг)	Бусад (мян,төг)		Бодын тоо	Богийн тоо	Өрхийн тоо	Ам бүлийн тоо
МД	1	2	3	4	5	6	7	8	9
2008	815123	104248	89650	621225	16087	1200	14887	369	1419
2007	426692.1	35300	29162.7	362229.4	9167	415	8752	574	2158
2006	461923.5	53895.5	1025	407011	12016	615	11409	992	4286
2005	261710	38282	3600	219828	8355	1076	7279	333	1312

Монгол улсын Засгийн газраас усны нөөцийн эх үүсвэрийг зохистой ашиглах замаар хүн ам, малын усны хангамжийг нэмэгдүүлэх, бэлчээрийн ашиглалтыг сайжруулахад анхаарал хандуулж, худаг, уст цэгийг шинээр гаргах, сэргээн засварлахад зориулан тодорхой хэмжээний хөрөнгө зарцуулжээ. 2008 онд 100 худаг ашиглалтанд орсноос 89 буюу 89 хувь инженерийн хийцтэй худаг, 11 буюу 11.0 хувь нь энгийн уурхайн худаг юм. (Хавсралт 48). Хүснэгт 29

2008 ОНД ШИНЭЭР ГАРГАСАН ХУДГИЙН ТАЙЛАН

2008 ОНД ШИНЭЭР ГАРГАХАД ХУДАГТ ХАЙЦАЙН											
Сумын дүн	Шинээр Гаргасан худаг тоо бүгд	Инженерийн хийцтэй 3+4+5	Үүнээс				Шинээр худаг гаргахад зарцуулсан хөрөнгийн хэмжээ мян,төг 8+9+10	улсын төсвийн хөрөнгөөр мян,төг	Гадаад орон олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрийн хөрөнгө /мян,төг/	Малчид иргэдийн өөрийн хөрөнгөөр /мян,төг/	Худаг шинээр гаргахад түр ажилласан орон нутгийн иргэдийн тоо
			Үүнээс			энгийн уурхайн					
			өрөмдмөл	богино яндант	бетон хашлагат уурхайн						
М/Д	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
2008	100	89	85	3	1	11	855906	466186	175450	239570	150
2007	104	68	65	2	1	36	549609.8	341925.8	99400	108284	211
2006	91	58	55	2	1	33	367406.9	42556.9	141540	183310	326
2005	45	34	33	0	1	11	202240	7760	109730	84750	520

2008 ОНД ЗАСВАРЛАСАН ХУДГИЙН ТАЙЛАН

Сумын нэр	Засварла- сан худгийн тоо бүгд	Инженерийн хийцтэй (14+15+16)	Үүнээс					худаг засварлахад зарцуулсан хөрөнгийн хэмжээ мян.төг (19+20+21)	улсын төсвийн хөрөнгөөр /мян.төг/	Гадаад орон олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрийн хөрөнгө /мян.төг/	Малчид иргэдийн өөрийн хөрөнгөөр /мян.төг/	Худаг шинээр гаргахад түр ажилласан орон нутгийн иргэдийн тоо
			Үүнээс			энгийн уурхайн						
			өрөмдмөл	богино яндант	бетон хашлагат уурхайн							
М/Д	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	
2008	104	46	28	16	2	58	96780.6	65999	1000	28956.6	200	
2007	83	39	29	5	5	44	108864.6	73346	24600	10918.6	213	
2006	127	82	68	5	9	45	233098	39170	131248	62680	305	
2005	112	85	55	13	17	27	173593	33450	131716.6	8426.4	822	

VI. СУДАЛГАА

1994-2008 оны хоорондох малын тооны динамик эгнээний үндсэн

үзүүлэлтүүдийг тооцож үзвэл:

. Малын тооны динамик эгнээний хэлхээ үндсэн

үзүүлэлтүүдийн тооцоолол –Хүснэгт 30

Он	Нийт малын тоо мян.тол
1994	1629.9
1995	1766.4
1996	1867.9
1997	2048.4
1998	2238.5
1999	2218.1
2000	2022.1
2001	1668.0
2002	1598.0
2003	1475.6
2004	1551.4
2005	1780.2
2006	2173.2
2007	2626.5
2008	3002.9

1994-2008 оны хоорондох малын тоог хронологийн дунджын аргаар тооцоход

$$\bar{y} = \frac{y_1 + y_2 + \dots + y_{n-1} + y_n}{n-1} = \frac{29667.36}{14} = 2119.09$$

1994-2008 оны хооронд малын тоо нь дунджаар 2119.09 мянга байжээ.

2005-2008 оны малын тооны динамик эгнээний үндсэн үзүүлэлтүүдийн тооцоог дараахь хүснэгтээр харуулав.

Дээрх хүснэгтээс харахад 2008 онд малын тоо 2007 оныхоос 376.4 толгойгоор буюу 20.8 хувиар өсөхөд өсөлтийн 1.0 хувьд 26.27 мян. толгой мал ногдлоо.

2005 оноос хойших малын тооны өсөлтийн дундаж хурдыг тодорхойлбол:

Динамик эгнээний үндсэн үзүүлэлтүүдийг хэлхээгээр буюу өмнөх онтой нь харьцуулан гаргахаас гадна тухайн нэг суурь онтой харьцуулан гаргаж болно.

Малын тооны динамик эгнээний суурь үндсэн үзүүлэлтүүдийн тооцоолол.

Хүснэгт 31


	Малын тоо, мян.тол	Суурь абсолют цэвэр өсөлт, мян.тол	Суурь өсөлтийн хурд (2005=100%)	Суурь цэвэр өсөлтийн хурд (%)
2005	1780.24		100	0
2006	2173.24	-393	122.1	22.1
2007	2626.54	-453.3	147.5	47.5
2008	3002.95	-376.41	168.7	68.7

Малын тооны динамик эгнээний хэлхээ үндсэн үзүүлэлтүүдийн тооцоолол- Хүснэгт 32

Онууд	Малын тоо, мян.тол	Абсолют цэвэр өсөлт	Хэлхээ өсөлтийн хурд (%)	Хэлхээ цэвэр өсөлтийн хурд (%)	Цэвэр өсөлтийн нэг хувьд ногдох утга
2004	1551.37				
2005	1780.24	228.9	114.75	5.1	15.51
2006	2173.24	393.0	122.08	14.7	17.80
2007	2626.54	453.3	120.86	22	21.73
2008	3002.95	376.4	114.33	20.8	26.27

Дээрх хүснэгтээс харахад 2008 онд малын тоо 2007 оныхоос 376.4 толгойгоор буюу 20.8 хувиар өсөхөд өсөлтийн 1.0 хувьд 26.27 мян.толгой мал ногдож байсан байна. 2004 оноос хойших малын тооны өсөлтийн дундаж хурдыг тодорхойлбол: Динамик эгнээний үндсэн үзүүлэлтүүдийг хэлхээгээр буюу өмнөх онтой нь харьцуулан гаргахаас гадна тухайн нэг суурь онтой харьцуулан гаргаж болно.

Зураг 14



VII. ДҮГНЭЛТ, САНАЛ

I. Мал тооллогын бэлтгэл, зохион байгуулалтын талаар

2008 оны мал тооллогыг Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоолын дагуу 12 дугаар сарын 7-нд эхэлж, 10 хоногийн хугацаанд орон даяар амжилттай зохион байгуулан явууллаа. Тооллого явуулах товыг наашлуулж, үргэлжлэх хугацааг харьцангуй уртасгасан нь мал, тэжээвэр амьтдыг тооллогод бүрэн хамруулах, тооллогыг холбогдох журам, зааврын дагуу чанартай сайн гүйцэтгэх нөхцлийг бүрдүүлсэн гэж үзэж байгаа юм.

Мал тооллогын бэлтгэлийг сайтар хангах талаар ҮСХ, ХХААЯ болон аймаг, орон нутгаас ихээхэн анхаарч, тооллогыг хэрхэн зохион байгуулж явуулах талаар төв, орон нутгийн холбогдох албан тушаалтнуудад тусгай программын дагуу семинар, ярилцлага хийж, тодорхой чиглэл өгч ажилласны дээр, радио, телевиз, хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр сурталчлах ажлыг өргөн хэмжээнд зохион байгуулав.

Түүнчлэн ХХААГ-тай хамтран бүх суманд тооллогын явцад хяналт тавих ажилтнуудыг томилон ажиллуулж, аймаг, орон нутгаас тооллогыг зохион байгуулах нарийн төлөвлөгөө, зураглал гарган, бэлтгэл зохион байгуулалтыг сайтар хангаж ажилласан нь тооллогыг чанартай явуулахад нөлөөлсөн гэж үзлээ.

Ихэнх сум мал тооллогын үргэлжлэх хугацааг бодолцсон нарийн төлөвлөгөө, зураглал гарган ажилласан.

II. Мал тооллогын зардлын талаар

Монгол улсын засгийн газрын 2004 оны 224 тоот тогтоолоор мал тооллогын зардлыг бүх шатны Засаг даргын Тамгын газрын жил бүрийн төсөвт тусгаж байхаар заасан хэдий ч энэ заалт хэрэгжихгүй байгаагаас мал тооллогын зардалтай холбоотой санал, хүсэлтийг орон нутгаас ирүүлсээр байна.

Мал аж ахуйн салбар нь манай орны эдийн засгийн гол салбарын нэг бөгөөд эдийн засгийн үндсэн үзүүлэлт болох салбарын нэмэгдэл өртгийг үнэн зөв, бодитой тооцоход мал тооллогын үр дүн ихээхэн чухал юм. Иймд энэ ажилд бүх шатны удирдлагууд анхааралаа хандуулж, зохих зардлыг жил бүрийн төсөвтөө тусгайлан суулгаж, тооллогын үр дүнд ач холбогдол өгч ажиллах шаардлагатай.

III. Сум, орон нутгийн удирдлага, малчдаас тавьсан санал

Сум, орон нутгийн засаг захиргааны бүх шатны удирдлага, малчдаас мал тооллоготой холбоотой ирүүлсэн саналуудын дийлэнх нь мал тооллогыг явуулах төсөв, зардал болон малд ноогдуулж байгаа татварын асуудалд чиглэсэн байна.

Үүнд:

A.Мал тооллогын зардлын талаар

- Мал тооллогын зардлыг 2004 оноос Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоолын 2 дугаар заалтын дагуу аймаг, сумын түвшинд төсөвт нь тусгайлан суулгаж өгөх

Б.Малд ногдуулж байгаа татварын талаар

- Өрхийн ам бүлийн гишүүдийн тоогоор малыг татвараас чөлөөлдөг явдлыг болиулах, энэ нь өрхийг хуурамчаар салгах, нэг хүн малаа 2-3 суманд салгаж тоолуулах үндсэн шалтгаан болж байгааг анхаарах
- Мал бүхий иргэнээс иргэний орлогын татвар, бэлчээр ашигласны татвар гэж 2 төрлийн татвар авч байгаа нь 2 давхар татварын ачаалалтай болж байгаагаас иргэд малаа тоолуулахгүй тооллогоос зайлсхийх хандлага гарч байна. Иймд татварын ачааллыг хөнгөрүүлж өгөх
- Отроор яваа өрхөөс малын татварыг үндсэн сум, отор хийж яваа сум давхардуулж авах явдал байгаагаас иргэд хохирч байгаа тул холбогдох байгууллагуудаас зохицуулж өгөх
- Ангийн зориулалттай бус буунаас татвар авч байна, үүнийг ялгавартай тогтоож өгөх

В.Бусад санал

- Сүүлийн үед малын хулгай ихсэж, олон малчид малаа хулгайд алдах боллоо. Аймаг, орон нутгийн төр захиргааны байгууллага, цагдаагийн байгууллагын хяналтыг сайжруулах, малчдад үйлчлэх үйлчилгээг ойртуулах
- Жил бүрийн тооллогод ач холбогдол өгч малаа биечлэн тоолуулдаг, татвараа хугацаанд нь төлж барагдуулдаг малчдыг шагнаж урамшуулдаг байх
- Малчдад үзүүлж байгаа тусламжийг хуваарилахдаа малын тоог харгалзаж үздэгийг болих, малчдад тусламж үзүүлэх, малжуулахдаа багийн хурлаар хэлэлцүүлдэг болох
- Мал тооллогын үеэр малаа нуух, дарах, амаар тоолуулах, худалдах, шилжүүлэх зэрэг зөрчилд хүлээлгэх хариуцлага тодорхой бус байгаа тул захиргааны хариуцлагын тухай хуульд өөрчлөлт хийж өгөх зэрэг саналууд байна.

IV. Мал тооллогын дүнгийн талаар

2008 оны жилийн эцэст манай аймгийн малын тоо, толгой 3002.9 мянгад хүрч, 2007 оныхоос 376.41 мянга буюу 14.3 хувиар өслөө. Тооллогын дүнгээр тэмээний тоо 2.37 мянга, адуу 212.72 мянга, үхэр 171.55 мянга, хонь 1449.79 мянга, ямаа 1166.49 мянгад хүрч, 2007 оныхоос тэмээ 0.03 , мянга, үхэр 14.39 мянга, хонь 200.52 мянга, ямаа 163.48 мянган тус тус өсч, адуу 2.2 толгойгоор харин мянгаар буурав.

2008 онд байгаль, цаг уурын байдал тааламжтай байж, бойжуулсан төлийн тоо 892.62 хүрч 2007 оныхоос 67.07 мянгаар нэмэгдсэн байна. Том мал хорогдол урьд оноос 80.04 мянгаар , хээл хаясан хээлтэгч 17.38 , сувайрсан хээлтэгч 19.67 мянгаар тус тус өсчээ. 2008 онд мянга болон түүнээс дээш малтай өрхийн тоо 422 болж 2007 оныхоос 85-аар өслөө. Гэвч энэ өсөлтийг чанарын талаас нь авч үзвэл цаашид анхаарах асуудлууд нилээд бий.

2008 оны малын өсөлтийн 38.84 хувийг ямааны тоо толгойн өсөлт хангажээ.

2008 онд бог малын 44.58 хувийг ямаа эзэлж байгаа бөгөөд ашиг шимийн гол бүтээгдэхүүн болох ноолуурын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор ямааг ихээр өсгөх хандлага ажиглагдсаар байна.

Түүнчлэн малчид отор нүүдэл хийх нь харьцангуй багассан, олон суурь, өрх хамтдаа нутаглах болсон зэрэг нь бэлчээрийн даацад муугаар нөлөөлж, хөрс сулрах, цөлжих байдал ажиглагдаж, байгаль орчинд сөргөөр нөлөөлжээ.

Мэргэжлийн байгууллагууд гаргаж байгаа тоо мэдээлэл дээр үндэслэн судалгаа, шинжилгээ хийж, цаг уурын ижил төстэй бусад орны мал маллагаа, арга туршлага, малаас авах ашиг шимийн гарц зэргийг судалж, амьдралд нэвтрүүлэх санаачлагатай ажиллах шаардлагатай байна. Мөн одоогийн баримталж байгаа мал аж ахуйн норм, норматив, аргачлал зэрэг нь зарим талаар хуучирч, мөрдөхөд хүндрэлтэй байгааг харгалзан энэ талаар судалгаа явуулах, норм, нормативийг шинэчлэн тогтоох ажлыг зохион байгуулах нь зүйтэй юм.

СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Ж. ОТГОНЧУЛУУН

Малчдын тоо, бүрэлдэхүүн.

	Малчдын тоо						үүнээс 2008 оноор						2008% 2007	Нэг малчинд ногдох мал (толгой)			
	2005	2006	2007	2008	үүнээс		16-34 35-59 эр	насаар		хувийн жингээр		2005		2006	2007	2008	
					эмэг- тэй	хув- ийн жин		55-аас 60-аас дээш	16-34 35-59 эр	55-аас 60-аас дээш							
Алтанбулаг	1154	1120	1165	1067	459	43.0%	486	398	183	45.5%	37.3%	17.2%	91.6%	107	137	149	171
Аргалант	301	312	470	338	163	48.2%	97	161	80	28.7%	47.6%	23.7%	71.9%	153	187	148	241
Архуст	191	355	256	317	96	30.3%	145	133	39	45.7%	42.0%	12.3%	123.8%	194	152	210	187
Батсүмбэр	1451	1387	1555	1318	634	48.1%	614	556	148	46.6%	42.2%	11.2%	84.8%	31	39	44	66
Баян	421	316	371	378	165	43.7%	137	180	61	36.2%	47.6%	16.1%	101.9%	119	193	170	167
Баяндэлгэр	411	336	382	371	105	28.3%	129	177	65	34.8%	47.7%	17.5%	97.1%	165	237	238	285
Баянжаргалан	491	492	517	500	243	48.6%	225	224	51	45.0%	44.8%	10.2%	96.7%	206	233	259	267
Баян-Өнжүүл	1100	1174	1330	1436	430	29.9%	471	501	464	32.8%	34.9%	32.3%	108.0%	115	129	131	125
Баянхангай	385	340	443	495	187	37.8%	201	221	73	40.6%	44.6%	14.7%	111.7%	120	167	155	175
Баянцагаан	1054	906	845	830	433	52.2%	374	315	141	45.1%	38.0%	17.0%	98.2%	103	134	153	147
Баянцогт	374	360	593	622	219	35.2%	203	247	172	32.6%	39.7%	27.7%	104.9%	142	181	144	172
Баянчандмань	255	340	298	393	132	33.6%	97	223	73	24.7%	56.7%	18.6%	131.9%	114	113	150	150
Борнуур	537	629	714	910	410	45.1%	341	374	195	37.5%	41.1%	21.4%	127.5%	97	104	114	115
Бүрэн	1563	1387	1560	1247	610	48.9%	558	472	217	44.7%	37.9%	17.4%	79.9%	79	108	115	135
Дэлгэрхаан	608	698	672	634	316	49.8%	300	228	106	47.3%	36.0%	16.7%	94.3%	92	94	125	112
Жаргалант	349	306	548	558	236	42.3%	241	208	109	43.2%	37.3%	19.5%	101.8%	142	204	165	231
Заамар	546	561	671	705	341	48.4%	308	319	78	43.7%	45.2%	11.1%	105.1%	100	129	146	186
Лүн	701	886	749	774	336	43.4%	344	317	113	44.4%	41.0%	14.6%	103.3%	143	135	202	238
Мөнгөнморьт	584	546	652	638	267	41.8%	299	254	85	46.9%	39.8%	13.3%	97.9%	47	61	60	96
Өндөрширээт	633	637	680	720	306	42.5%	375	255	90	52.1%	35.4%	12.5%	105.9%	115	137	169	186
Сүмбэр	155	131	128	151	79	52.3%	42	77	32	27.8%	51.0%	21.2%	118.0%	114	171	227	260
Сэргэлэн	751	465	544	473	235	49.7%	161	222	90	34.0%	46.9%	19.0%	86.9%	89	164	130	167
Угтаал	676	412	613	661	271	41.0%	210	318	133	31.8%	48.1%	20.1%	107.8%	63	127	133	118
Цээл	415	395	399	592	288	48.6%	123	318	151	20.8%	53.7%	25.5%	148.4%	81	115	167	163
Эрдэнэ	949	1006	1091	989	435	44.0%	375	423	191	37.9%	42.8%	19.3%	90.7%	95	107	116	155
Эрдэнэсант	1209	1116	1417	1440	552	38.3%	533	692	215	37.0%	48.1%	14.9%	101.6%	112	152	156	182
Зуунмод	286	313	267	305	147	48.2%	72	117	116	23.6%	38.4%	38.0%	114.2%	86	104	147	135
Бүгд дүн	17098	17550	18930	18862	8095	42.9%	7461	7930	3471	39.6%	42.0%	18.4%	99.6%	91	101	139	159
Төвийн бүс	3998	4345	830.2	822.2	340.8	41.4%	1564	1553	994	36.2%	39.1%	24.7%	99.0%	100	134	142	149
Зүүн бүс	3124	3047	544.8	532.2	218.5	41.1%	1310	1391	492	41.1%	44.1%	14.8%	97.7%	138	164	175	193
Баруун бүс	6380	6736	800.4	807.6	356.3	44.1%	2952	3140	1176	40.3%	43.3%	16.4%	100.9%	101	130	152	166
Хойд бүс	3596	3422	615.1	612.9	267.6	43.7%	1635	1846	809	34.4%	45.1%	20.5%	99.6%	113	143	142	177


Малчин өрхийн тоо.

	Малчин өрхийн тоо				2008%	Нэг малчин өрхөд ногдох мал			
	2005	2006	2007	2008	2007	2005	2006	2007	2008
